

2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн УЗ-ийн хуралдаанаар Шүүгчдийн холбооны 2022 онд төлөвлөж, хийж хэрэгжүүлсэн ажлыг дүгнэн хэлэлцэв.

Шүүгчдийн холбоо 2022 онд 9 чиглэлээр 37 төрлийн ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд 93 хувьтай биелүүлсэн байна гэж дүгнэлээ.

Шүүгчдийн холбооноос 2022 оны ажлын гүйцэтгэлд
манлайлан гар бие оролцсон шүүгчдийн нэрс,
оролцсон ажлын товч тайлан мэдээлэл

Дотоод зохион байгуулалтын чиглэлээр

Холбооны дүрмийн 3.2.1-т заасан чиглэлээр

Холбооны дүрмийн 3.1.3-д заасан чиглэлээр

Холбооны дүрмийн 3.1.4-д заасан чиглэлээр

Холбооны дүрмийн 3.1.5-д заасан чиглэлээр

Холбооны дүрмийн 3.1.6-д заасан чиглэлээр

Холбооны дүрмийн 3.1.7-д заасан чиглэлээр

Холбооны дүрмийн 3.1.8-д заасан чиглэлээр

Шүүгчдийн холбооноос 2022 оны ажлын гүйцэтгэлд манлайлан гар бие оролцсон шүүгчдийн нэрс, оролцсон ажлын онцлох мэдээлэл

Онцлох ажлууд	Зохион байгуулж, манлайлж оролцсон шүүгч	Хэдэн шүүгч хамрагдсан
2022 оны 1 сард холбооны пэйж хуудсыг дагагчийн тоо 2800 болж нэмэгдэв.	Холбооны тэргүүн Ж.Оюунтунгалаг, УЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал М.Наранчимэг, туслах Г.Цолмонгэрэл	37 Салбар хорооны тэргүүн, шүүгч нараас ирүүлсэн мэдээ, мэдээлэл
“Шударга ёсны хэмжүүр” сэтгүүлийг цахимаар 2021 оны хоёр дахь дугаар 25, 2022 онд №26, №27 бэлтгэн гаргав.	НИДЗШШ-ийн шүүгч Ц.Ичинхорлоо Гүйцэтгэх захирал М.Наранчимэг, туслах Г.Цолмонгэрэл, эх бэлтгэгч С.Энхбаяр	“Шударга ёсны хэмжүүр” сэтгүүлийг олон нийтэд түгээх, МШХ-ны үйл ажиллагааг сурталчлан таниулахад гишүүн шүүгч нар идэвхтэй оролцов.

Шүүгчдийн холбооноос 2022 оны ажлын гүйцэтгэлд манлайлан гар бие оролцсон шүүгчдийн нэрс, оролцсон ажлын онцлох мэдээлэл

Онцлох ажлууд	Зохион байгуулж, манлайлж оролцсон шүүгч	Хэдэн шүүгч хамрагдсан
УЗ-ийн хуралдаанаар Сэтгүүлийн эрхлэгч болон гишүүдийг шинээр сонгож, батлав	УЗ-ийн хуралдааны шийдвэрээр	Сэтгүүлийн зөвлөлийг 7 хүний бүрэлдэхүүнтэй сонгов
“Шүүх эрх мэдэл” эмхэтгэлд МШХ-ны үйл явдлын хураангуйг хагас жилээр 2 удаа гаргав	Холбооны Тэргүүн, УЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх захирал М.Наранчимэг, туслах Г.Цолмонгэрэл	2022 оны ШЕЗ-ийн “Шүүх эрх мэдэл” эмхэтгэлийн дугаар 2 болон 3-т Шүүгчдийн холбооны 2022 оны ажлын гүйцэтгэлийн хураангуйг товчлон оруулав
Нийслэлийн 6-р сургуулийн ахлах ангийн сурагчдад НЭИТГ-ын байр болон шүүхийн танхим, шүүх хуралдааны онцлог, үйл ажиллагааны талаар уулзалт ярилцлагыг зохион байгуулав	НИДЗШШ-ийн шүүгч Д.Нямбазар, гүйцэтгэх захирал М.Наранчимэг, туслах А.Энхбаатар	Нийслэлийн Эрүү, Иргэний Тамгын газартай хамтран 25 сурагч, 2 багш ирж хамрагдав

Шүүгчдийн холбооноос 2022 оны ажлын гүйцэтгэлд манлайлан гар бие оролцсон шүүгчдийн нэрс, оролцсон ажлын мэдээлэл

Онцлох ажлууд	Зохион байгуулж, манлайлж оролцсон шүүгч	Хэдэн шүүгч хамрагдсан
<p>“US Speak-г” хөтөлбөрийг Шүүгчдийн холбоо санаачлан АНУ-ын ЭСЯ-ны Олон нийттэй харилцах хэлтэстэй, ШЕЗ, Шүүхийн сахилгын хороо, УДШ-ийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнтэй хамтран 400 гаруй шүүгчийг хамруулсан туршлага судлах сургалт, уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулав</p>	<p>НИДЗШШ-ийн Ерөнхий шүүгч, Холбооны тэргүүн Ж.Оюунтунгалаг болон УЗ-ийн бүх гишүүд, гадаад харилцааны дэд хорооны ахлагч Ц.Эрдэнэчимэг, А.Сарангэрэл</p> <p>А.Сарантуяа Ц.Амаргэрэл</p> <p>Гүйцэтгэх захирал М.Наранчимэг, туслах Г.Цолмонгэрэл</p>	<p>“US-Speakers-22” хөтөлбөрийг 2022.11.02-13-нд хэрэгжүүлэв.</p> <p>Шүүгч нарт зориулсан сургалтад 400 гаруй шүүгч оролцсоноос:</p> <p>Танхимаар 150 гаруй шүүгч оролцсон гэж УДШ-ийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс мэдээлэв. Шүүгч ба олон нийт” хэлэлцүүлэгт 60 гаруй хүн оролцов. ШЕЗ-ийн хурлын танхимд болсон “Цахим орчин дахь зүй бус дайралт” сэдэвт уулзалт ярилцлагад 30 гаруй хүн оролцов.</p>
<p>ШЕЗ-ийн Тамгын газартай хамтарч Шүүхийн тамгын газрын ажилтан, шүүхийн ХМ-ийн ажилтан нарыг хамруулсан цахим болон танхимаар оролцуулсан туршлага судлах сургалт, уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан</p>	<p>Гадаад харилцааны дэд хорооны ахлагч Ц.Эрдэнэчимэг, А.Сарангэрэл</p> <p>Гүйцэтгэх захирал М.Наранчимэг, туслах Г.Цолмонгэрэл</p>	<p>ШЕЗ-ийн хурлын танхимд 50 гаруй хүн, цахимаар орон нутгийн шүүхийн Тамгын газрын нийт ажилтнууд бүгд хамрагдав.</p>

“Mentorship” хөтөлбөрийн хүрээнд 18 шүүгч Шихихутуг Их Сургуулийн 3 болон 4 дүгээр ангийн нийт 330 гаруй оюутан, эчнээ ангийн 40 гаруй оюутанд хичээл заав.

Шүүгч багш нар “Хуулийн хэрэглээ-1, II,
“Хуулийн процессын эрхзүй”
хичээлүүдийг оров.

“Mentorship” хөтөлбөрийн хүрээнд 18 шүүгч Шихихутуг Их Сургуулийн 3 дугаар ангийн нийт 18 оюутанг менторлан “багш-шавь”-ийн харилцаа тогтоон сургаж эхэллээ.

Шүүгч багш нарын нэрс	Эрүүгийн хэргийн шүүгчид:	Иргэний хэргийн шүүгчид:	Захиргааны хэргийн шүүгчид:
“Хуулийн хэрэглээ-I, II, “Хуулийн процессын эрхзүй” хичээлүүдийг зааж буй шүүгчид:	Ц.Эрдэнэчимэг, С.Аюушжав, С.Болортуяа, Л.Галбадар, Г.Золбоо, Т.Алтантуяа, М.Түмэннаст	Ж.Оюунтунгалаг, Б.Хишигбаатар Б.Мандалбаяр, Н.Оюунтуул, Ц.Оюунбилэг, Н.Батзориг, Д.Нямбазар	Захиргааны хэргийн шүүгчид: А.Сарангэрэл, Б.Адъяасүрэн, М.Батзориг, Н.Дамдинсүрэн

Шүүгчдийн холбооноос 2022 оны ажлын гүйцэтгэлд манлайлан гар бие оролцсон шүүгчдийн нэрс, оролцсон ажлын онцлох мэдээлэл

Онцлох ажлууд	Зохион байгуулж, манлайлж оролцсон шүүгч	Хэдэн шүүгч хамрагдсан
<p>Шүүгчдийн холбоо, АТГ-ын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран ажиллав.</p> <p>-Шүүгч, -Шүүхийн ажилтан, -Иргэдэд зориулсан 8 төрлийн постер хийлгэв.</p>	<p>Холбооны тэргүүн Ж.Оюунтунгалаг, УЗ-ийн гишүүн Ч.Хосбаяр, А.Сарангэрэл, Н.Батзориг</p> <p>Шүүгч Б.Гансүх, Ц.Амаргэрэл</p> <p>Гүйцэтгэх захирал М.Наранчимэг, туслах Г.Цолмонгэрэл</p>	<p>Постерын үг, хэллэг, текстын агуулгыг Салбар хороогоор хэлэлцүүлэн нийт шүүгч нарыг хамруулан, УЗ-ийн гишүүд оролцож цахим хурлаар ярилцан хэлэлцэж, тус хурлаас шүүгч нарын бүрэлдэхүүнтэй ажлын алба гаргаж энэ хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэв.</p>
<p>Төслийн хүрээнд 2 нэвтрүүлгийг АТГ-ын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран хийхээр төлөвлөсөн.</p>	<p>Холбооны тэргүүн Ж.Оюунтунгалаг, гадаад харилцааны хорооны ахлагч Ц.Эрдэнэчимэг нар нэвтрүүлэгт ярилцлага өгч, Шүүгчдийн холбоо, АТГ хамтран бүтээв.</p>	<p>Хамтарсан нэвтрүүлгийг “Шүүгч ба Олон нийт” хэлэлцүүлгийн үеэр бичиж, МҮОНТ болон АТГ ба Шүүгчдийн холбооны сайт пэйж хуудсуудаар 2022.10.26-ны өдөр иргэд олон нийтэд хүргэв.</p>

Шүүгчдийн холбооноос 2022 оны ажлын гүйцэтгэлд манлайлан гар бие оролцсон шүүгчдийн нэрс, оролцсон ажлын онцлох мэдээлэл

Онцлох ажил	Зохион байгуулж, манлайлж оролцсон шүүгч	Хэдэн шүүгч хамрагдсан
<p>Австрали улсад англи хэлний заах аргазүйгээр магистр хамгаалсан багш А.Ариунтуяагаар хичээл заалгав.</p> <p>31 шүүгч нэрсээр бүртгүүлсэн. Үүнээс 18 шүүгч англи хэлний анхан шатны ахисан түвшний хичээлд хамрагдав</p>	<p>Холбооны тэргүүн Ж.Оюунтунгалаг, УЗ-ийн гишүүн А.Сарангэрэл</p> <p>Холбооны гадаад харилцааны хорооны ахлагч Ц.Эрдэнэчимэг,</p>	<p>Ц.Наранчимэг, Х.Дашдэчмаа С.Болортуяа, Н.Батзориг Ж.Байгалмаа, Т.Алтантуяа Б.Болор-Эрдэнэ, Г.Уртнасан Г.Жаргалтуяа, С.Өлзий-Отгон Б.Дэнсмаа, Б.Сугиржав Г.Уртнасан, Х.Байгалмаа П.Пагма Ц.Ариунзул болон холбооны гүйцэтгэх захирал хамрагдав.</p>

Шүүгчдийн холбооноос 2022 оны ажлын гүйцэтгэлд манлайлан гар бие оролцсон шүүгчдийн нэрс, оролцсон ажлын онцлох мэдээлэл

Онцлох ажил	Зохион байгуулж, манлайлж оролцсон шүүгч	Хэдэн шүүгч хамрагдсан
<p>“Ярьж буй хууль” нэвтрүүлгийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ТВ9, ТМ24, Өлзий, Соён гэгээрүүлэгч телевиз болон өөрийн холбооны сайт, пэйж хуудсуудаар дамжуулж олон нийтэд хүргэв.</p> <p>Нэвтрүүлгийг Live-аар дамжуулж олон нийтэд хүргэв.</p>	<p>БГД-ийн ИХАШШ-ийн шүүгч, нэвтрүүлгийн багийн ахлагч А.САРАНТУЯА, Х.Энхзаяа, ЗХАШШ-ийн шүүгч Б.Адъяасүрэн</p> <p>БГД-ийн ЭХАШШ-ИЙН ШҮҮГЧ С.Болортуяа</p> <p>Гүйцэтгэх захирал М.Наранчимэг, туслах Г.Цолмонгэрэл</p> <p>Найруулагч П.Сүхтулга, М.Лхагвасүрэн</p>	<p>“Ярьж буй хууль” нэвтрүүлэгт зочин шүүгчээр оролцсон шүүгч нар:</p> <p>Ж.Оюунтунгалаг, Ц.Эрдэнэчимэг, Э.Энэбиш, Б.Гансүх, Н.Оюунтуяа, Ц.Цэрэндулам, Г.Ганбаатар, Н.Гэрэлтуяа, Б.Азбаяр, А.Сарангэрэл, Т.Мөнх-Эрдэнэ, Б.Мандалбаяр, Т.Жавхлантөгс, Н.Гэрэлтуяа, Б.Марина, Д.Золзаяа, Ц.Мөнхтулга, М.Мөнхбаатар, Н.Дуламсүрэн, Б.Хишигбаатар, П.Туяа, С.Өлзий-Отгон, Т.Түмэннаст, П.Цэцэгдулам, О.Чулуунчимэг, И.Ганбат, А.Түвшинтулга, Б.Зориг, Б.Батцэрэн</p>

Зохион байгуулж, манлайлж оролцсон шүүгч:

Архангай аймаг дахь Салбар хорооны тэргүүн

А.Түвшинтулга,

Сэлэнгэ аймгийн салбар хорооны тэргүүн

Б.Мөнхзаяа

Архангай болон Сэлэнгэ аймгийн салбар хороо “Ярьж буй хууль” нэвтрүүлгийг орон нутгийн телевиз, сайтаар олон нийтэд хүргэж ажиллав.

Шүүгчдийн холбооноос 2022 оны ажлын гүйцэтгэлд манлайлан гар бие оролцсон шүүгчдийн нэрс, оролцсон ажлын онцлох мэдээлэл

Онцлох ажил	Зохион байгуулсан Шүүгчдийн холбоо	танхимаар	цахимаар
<p>“Ярих ур чадвар, эфирт биеэ хэрхэн авч явах вэ”? сургалтыг ШЕЗ-ийн хурлын танхимд явуулав.</p> <p>Сургалтад танхим болон цахимаар нийт 50 орчим шүүгч хамрагдав.</p>	<p>Удирдах зөвлөлийн гишүүд, Гүйцэтгэх захирал М.Наранчимэг, туслах Г.Цолмонгэрэл</p> <p>МУСГЗ, зохиолч, сэтгүүлч, хөтлөгч Ш.Гүрбазар, МУГЖ Н.Батцэцэг, МУСГЗ, нэвтрүүлэгч С.Гантөмөр нар лекц уншив.</p>	15	35

Шүүгчдийн холбооноос 2022 оны ажлын гүйцэтгэлд манлайлан гар бие оролцсон шүүгчдийн нэрс, оролцсон ажлын онцлох мэдээлэл

Онцлох ажил	Манлайлж биеэр оролцсон шүүгч нар	Үйл ажиллагаанд хамрагдсан шүүгчид
<p>“US Speaker” хөтөлбөрийн хүрээнд Сэлэнгэ аймгийн салбар хороотой танилцаж, УЗ-ийн гишүүд болон холбооны шүүгч гишүүд орон нутагт ажиллав.</p>	<p>Сэлэнгэ аймаг дахь салбар хорооны тэргүүнийг түр орлон гүйцэтгэгч Г.Давааренчин, Ерөнхий шүүгч Б.Буянжаргал, Эрүүгийн анхан шатны шүүгч Ц.Амаргэрэл болон Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн Тамгын газрын дарга төлөөлөл, салбарын шүүгчид</p>	<p>Сэлэнгэ аймаг дахь Шүүгчдийн холбооны салбар тэргүүн, Сэлэнгэ аймаг дахь шүүгчид, Шүүхийн тамгын газрын дарга болон Шүүгчдийн холбооны тэргүүн, УЗ-ийн гишүүдийн төлөөлөл гүйцэтгэх захирал, холбооны гишүүн шүүгч нар</p>
<p>ШЕЗ-тэй нөлөөллийн мэдүүлгийг үр дүнтэй болгох асуудлаар хамтран ажиллах хүрээнд нөлөөллийн мэдүүлгийн үр нөлөө, шийдвэрлэлтийг сайжруулах, холбогдох эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор ШЕЗ, Шүүгчдийн холбоо хамтарсан ажлын баг байгуулав.</p>	<p>Удирдах зөвлөлийн гишүүн, УДШ-ийн шүүгч, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаяр БГД-ийн ИХАШШ-ийн шүүгч, А.Сарантуяа, Х.Энхзаяа, Ч.Батчимэг Дундговь аймгийн ЗХАШШ-ийн шүүгч Б.Сугиржав, Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүгч Б.Болор-Эрдэнэ нар ажлын хэсэгт орж ажиллахаар хүсэлт ирүүлсэн.</p>	<p>Удирдах зөвлөлийн гишүүн УДШ-ийн шүүгч, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаяр, БГД-ийн ИХАШШ-ийн шүүгч Ч.Батчимэг, Дундговь аймгийн ЗХАШШ-ийн шүүгч Сугиржав нар ажлын багт орж ажилуулахаар ШЕЗ-өөс албан бичиг ирүүлэв.</p>

Шүүгчдийн холбооноос 2022 оны ажлын гүйцэтгэлд манлайлан гар бие оролцсон шүүгчдийн нэрс, оролцсон ажлын онцлох мэдээлэл

Онцлох ажил	Ажил гүйцэтгэсэн Шүүгчдийн холбоо	Хамрагдсан Шүүгчийн тоо
Нийт шүүгчдийг эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт оруулахаар төлөвлөв	Шүүгчдийн холбооны гүйцэтгэх захирал, туслах зохион байгуулав	ТТАХНЭ-ийн урьдчилан сэргийлэх үзлэг болон Хавдар судлалын Үндэсний төв эмнэлэгт нийт 140 гаруй шүүгчийг хамруулав.
Ерөнхийлөгчийн зарлигаар тэтгэвэрт гарсан шүүгч нартаа хүндэтгэл үзүүлэх	Шүүгчдийн холбоо	2022 онд нийт 17 шүүгчид хүндэтгэл үзүүлж, холбооны логотой үзэг хадгалуулав

- Шүүгчдийн холбооны тэргүүн, Удирдах зөвлөлийн гишүүд холбооны үйл ажиллагаанд идэвх чармайлттай оролцсон нийт гишүүн шүүгч нартаа талархаж буйгаа илэрхийлье.
- Шүүгч та бүхний дэмжлэг, оролцоотой төлөвлөсөн ажлуудыг амжилттай хэрэгжүүлсэн гэж дүгнэв.

ШҮҮГЧДИЙН ХОЛБОО
УБ 2022